

СЭТГҮҮЛ ЗҮЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГА, ЗАРЧМЫН
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

М.Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн тэргүүлэх профессор, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн

Түлхүүр үг: арга зүй, судалгааны онол-түүхийн хандлага, синхрон ба диахроны арга, мэдээлэл харилцааны шинжлэх ухаан, хэвлэлийн хэв маяг.

Сэтгүүл зүйн судалгааны арга зүйн асуудлыг дэвшүүлэн тавих явдал бол шинжлэх ухааны мэдлэгийн хөгжлийн үр дүн юм. Орчин үед шинжлэх ухааны шинэ ололт амжилтанд зөвхөн судалгааны материалыг өргөтгөх, баяжуулан гүнзгийрүүлэх төдийгүй, түүнийг судлах хуучин уламжлалт аргуудыг боловсронгуй болгох, шинэ арга, хандлагуудыг олж илрүүлэх замаар хүрэх боломжтой гэдэг нь улам бүр тодорхой болж байна. Тиймээс шинжлэх ухааны мэдлэгийн бүтцэд өдөр тутмын судалгааны үр дүнгээс гадна судлагдахууныг таньж мэдэх, болж байгаа үйл явцын учир шалтгааныг тайлбарлах, ойлгоход чухал үүрэг гүйцэтгэдэг судалгааны

зарчим, арга, хандлага болон логик сэтгэлгээний ач холбогдол эрс өсөн нэмэгдэж байна.

Орчин үеийн нийгэм-хүмүүнлэгийн шинжлэх ухааны гол онцлог бол арга зүйн судалгааг өргөтгөх эрчимтэй хөгжүүлэх явдал бөгөөд энэхүү “арга зүй” хэмээх ойлголтын агуулгын талаар эрдэмтэн судлаачдын дунд маргаан, мэтгэлцээн улам хүчтэй явагдах хандлага ажиглагддаг. Ялангуяа арга зүйн танин мэдэхүйн онол, судалгааны аргуудын ба зарчмуудын нийлбэр болох мөн чанар, арга зүйн судлагдахуун ба бүтэц, шинжлэх ухаан дахь арга зүйн болон онолын асуудлын харьцаа, танин мэдэхүйн арга ба арга зүйн талаарх асуудал ихээхэн анхаарал татах болжээ.

Шинжлэх ухааны мэдлэгийн энэ чиглэлийн хүрээнд сэтгүүл зүйн түүх ба онол, олон нийтийн мэдээллийн харилцааны салбарын арга зүйн судалгааг

сонирхох хандлага нэмэгдэх шинжтэй байна. Сэтгүүл зүй судлаачид арга зүйн янз бүрийн асуудлыг тодорхой хэмжээгээр хөндөж байсан бөгөөд тэдний үзэл бодлыг бүхэлд нь тусгах боломжгүй учир зөвхөн сэтгүүл зүйн тодорхой нэг чиглэл, салбарын судалгааны арга зүйг боловсруулах, боловсронгуй болгох, энэ асуудлыг дэвшүүлэн тавихад чухал ач холбогдол бүхий бие даасан бүтээлүүдийн талаар товч өгүүлье.

Монголын тогтмол хэвлэлийг 1895-1925 он хүртлэх хугацаанд гарч байсан сонин, сэтгүүлийн материалд тулгуурлан судлах арга зүй ба аргын асуудлыг хөндсөн анхны бие даасан бүтээл бол түүхийн шинжлэх ухааны доктор Г.Дэлэгийн “Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” (1965)¹ юм. Зохиогч цаашид тогтмол хэвлэлийн түүхийн судалгааг гүнзгийрүүлж хөгжүүлж, “Монголын хэвлэл”² (1971, 1972) хоёр боть нэг сэдэвт зохиол туурвисан бөгөөд сэтгүүл зүйн түүхийн судалгааны арга зүй, түүний дотор түүхийн эх сурвалж, нийтлэлийн агуулгыг судлах аргын эх суурийг тавьжээ. Сэтгүүл зүйн түүхийн судалгааны арга зүйг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан бүтээл бол хэл бичгийн ухааны доктор Л.Норовсүрэнгийн “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм”³ гурван боть, “Монголын нийтлэл”⁴ гурван боть нэг сэдэвт зохиол мөн. Ялангуяа сэт-

гүүл зүйг түүхчлэн судлах, ХМХ-үүдийн хэв маягийн судалгаа, нийтлэл нэвтрүүлгийн агуулгын судалгаа, эх сурвалжийн судалгааны арга зүйг боловсронгуй болгох, судалгааны нийтлэг аргуудыг манай сэтгүүл зүйн практикт нэвтрүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн юм.

Монголын сэтгүүл зүйн онолын судалгаа жинхэнэ утгаараа 1990-ээд оноос эхэлсэн бөгөөд наяд оны дунд үед гарсан доктор Г.Дэлэгийн “Хэвлэлийн онол, дадлага”⁵, Д.Нямсүрэнгийн “Сэтгүүлчийн ур чадвар”⁶, Т.Баасансүрэнгийн “Тэргүүн туршлагыг хэвлэлээр сурталчлах асуудалд”⁷ бүтээлийг эс тооцвол онолын асуудлыг тусгасан дорвитой бүтээл гараагүй юм. Харин 80-аад оны эхээр ЗХУ-д хэд хэдэн судлаач сэтгүүл зүйн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалж, 1995 онд МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхмийн дэргэд Сэтгүүл зүйгээр докторын (Ph.D) зэрэг хамгаалуулах мэргэшсэн зөвлөл байгуулсан нь сэтгүүл зүйн бүх чиглэлийн судалгааг, түүний дотор онолын судалгааг хөгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн. Мөн ОНМХ-ээр төрөлжсөн судалгаа хийх эх суурь тавигдаж, Т.Галдан, Ю.Эрдэнэтуяа, Ц.Пунсаа⁸ зэрэг судлаачид телесэтгүүл зүйн асуудлаар эрдмийн зэрэг хамгаалжээ. Өөрчлөлт шинэчлэлтийн үеийн сэтгүүл зүйн онол, практикийн асуудлуудыг нухацтай судалсан нэг сэдэвт зохиол бол эл бүтээлийг бичигчийн “Орчин үеийн Монголын сэтгүүл зүй” (Монголын

сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлага, онол, практикийн асуудлууд)⁹ хэмээх нэг сэдэвт зохиол юм. Энэ бүтээлд сэтгүүл зүйн судалгаанд түгээмэл хэрэглэдэг задлан шинжилж нэгтгэн дүгнэх, индукци, дедукци, харьцуулан судлах, диахрон ба сихроны арга, комфротацийн арга, социологийн судалгааны аргуудыг хэрэглэж, зарим аргыг Монголын сэтгүүл зүйн судлалд анх удаа хэрэглэснээр

сэтгүүл зүйн судалгааны арга зүйг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ.

Сүүлийн жилүүдэд сэтгүүл зүйн түүх, онол, практикийн асуудлуудыг нарийсгаж, нэлээд гүнзгийрүүлэн судлах хандлага ажиг-

лагдаж, судлаачид сэтгүүл зүйн шинэ чиглэлүүдэд анхаарлаа хандуулах явдал нэмэгдсэн нь ажиглагдаж байна. Судлаач Л.Норовсүрэн сонины бичлэгийн төрөл зүйл, Б.Болд-Эрдэнэ олон нийтийн мэдээллийн харилцаа, ОНМХ-ийн реклам сурталчилгаа, Ч.Чойсамба экологийн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүй, Д.Цэмбэл, Ч.Базар нар эрэн сурвалжлах сэтгүүл зүй, Д.Дагиймаа ОНМХ-ийн реклам сурталчилгаа, Т.Оюунбилэг мэдээллийн эх сурвалж, Л.Амарзаяа радиосэтгүүл зүй, Г.Өнөрбаяр PR буюу олон нийтийн харилцаа,

Л.Ариун экологийн сэтгүүл зүйн асуудлаар эрдмийн зэрэг хамгаалж, ном бичиж, өгүүлэл нийтлүүлсэн нь үүний тод жишээ юм. Судалгааны чиглэл олширч, судлаачдын тоо нэмэгдэж байгаа нь судалгааны арга зүй, арга нь тэр хэмжээгээр өргөжин тэлж, гүнзгийрч байгаагийн илрэл юм.

1980-аад оны дунд үеэс манай томоохон хэвлэл мэдээллийн байгууллагууд судалгаа эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран социологийн судалгаа хийж эхэлсэн нь сэтгүүл зүйн судалгааны арга зүйг баяжуулахад зохих нөлөө үзүүлсэн. Үүнд 1987 онд МСХ-ноос хүлээн

«

Манай ХМХ-ийн зарим төрөл, сэтгүүл зүйн зарим асуудал маш бага судласныг хэлэх хэрэгтэй. Тухайлбал, радио сэтгүүл зүй, цахим сэтгүүл зүй, мэдээллийн агентлаг, орон нутгийн ХМХ, сэтгүүлчийн ур чадвар, сонин хэвлэлийн дизайн, нийтлэлийн үр нөлөө, нийтлэл зүй, мэдээллийн багтаамж зэрэг олон арван асуудлыг нэрлэж болно.

»

авагчид болон сэтгүүлчдийн дунд явуулсан, 1983 онд МРТХГ ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнтэй хамтарч явуулсан судалгаа чухал ач холбогдолтой болсон. Сүүлийн жилүүдэд МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхим хүлээн авагчид болон сэтгүүлч уран бүтээлчдийн дунд ийм социологийн судалгааг хэд хэдэн удаа явуулж, тодорхой үр дүнд хүрсэн болно¹⁰. 1995 онд Данийн засгийн газрын Данида төслийн хүрээнд Монголын хэвлэлийн хүрээлэнг (МХХ) байгуулсан нь сэтгүүл зүйн практик

талын судалгааг хөгжүүлэх, ялангуяа мониторингийн судалгааны аргыг¹¹ өргөн нэвтрүүлэхэд зохих үүрэг гүйцэтгэсэн. Мөн ХМХ-ийн эрх зүйн орчныг судлахад "Глоб интернейшнл" ТББ нэлээд санаачлагатай ажиллаж, хэд хэдэн төсөл хэрэгжүүлж, гарын авлага хэвлүүлсэн нь зохих үр дүнд хүрсэнийг тэмдэглүүштэй. Энэ бүхэн нь сэтгүүл зүйн социологийн, мониторингийн, ажиглалтын аргыг ОНМХ-ийн судалгаанд хэрэглэх шинэ боломжийг нээж өгснөөрөө ихээхэн ач холбогдолтой юм.

Гэхдээ манай ХМХ-ийн зарим төрөл, сэтгүүл зүйн зарим асуудал маш бага судласныг хэлэх хэрэгтэй. Тухайлбал, радио сэтгүүл зүй, цахим сэтгүүл зүй, мэдээллийн агентлаг, орон нутгийн ХМХ, сэтгүүлчийн ур чадвар, сонин хэвлэлийн дизайн, нийтлэлийн үр нөлөө, нийтлэл зүй, мэдээллийн багтаамж зэрэг олон арван асуудлыг нэрлэж болно. Манай сэтгүүл зүй судлаачдын судалгааны дадлага, туршлага, сэтгүүл зүйн онолын талаарх суурь мэдлэг нимгэн, гадаад хэлний мэдлэг дутмаг, судалгааны материаллаг бааз сул зэрэг шалтгаануудаас болж сэтгүүл зүйн судалгааны арга зүй, аргыг сэтгүүл зүйн хөгжлийн өнөөгийн шаардлагын төвшинд бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Дүгнэж хэлбэл, Монголын сэтгүүл зүйн судалгааны арга зүй эхлэл төдий байгаа бөгөөд цаашид

арга зүйн асуудлыг тусгайлан судалж, судалгааны томоохон судлагдахууны хэмжээнд авч үзэх шаардлага тулгарч байна.

Сэтгүүл зүйн судалгааны арга зүй шинжлэх ухааны ойлголт болох нь. Юуны өмнө арга зүйн асуудлын талаарх сэтгүүл зүй судлаачдын санал бодол ихээхэн зөрчилтэй, хараахан нэг мөр болоогүй байгааг хэлэх хэрэгтэй. Тиймээс "Сэтгүүл зүйн судалгааны арга зүй" хэмээх ойлголтыг тодорхойлогч үндсэн категориудыг системчлэх, шинжлэх ухааны мэдлэгийн энэхүү онцгой салбарын өвөрмөц онцлогийг илрүүлэх, энэ талаарх янз бүрийн үзэл бодлыг нэгтгэн дүгнэх шаардлага тулгарч байна.

Хэдийгээр арга зүйн талаар олон янзын санал бодол байгаа ч арга зүйг аргуудын тухай сургаал, танин мэдэхүйн онол ба логик, өөрөөр хэлбэл шинжлэх ухааны нэгтгэн дүгнэсэн туршлага, түүний бодит байдлыг судлах арга болгон хувиргасан, логикийн үүднээс тунгаан бодсон түүхэн хөгжлийн болон ололт амжилтын үр дүн мөн гэж тодорхойлох хандлага голлох байр эзэлдэг. Арга зүйн ач холбогдол нь зөвхөн нэг л материалын хүрээнд "хатуу баригдахгүй", түүхэн хөгжлийн янз бүрийн үе шат, нөхцөл байдал, нийгмийн болон уран бүтээлийн үйл явцуудыг өргөн хүрээнд судлах замаар үе үеийн эрдэмтэн судлаачдад судалгааны өргөн боломжийг нээж өгөхөд

оршино. Арга зүй бол харьцангуй тогтвортой, тодорхой нэг аргын адил томоохон өөрчлөлтөд орохгүй бөгөөд түүний өөрчлөлт нь ямагт боловсронгуй болж, баяжин төгөлдөржихүйл явцаар илэнрдэг. Боловсронгуй болгох нь судлаач бүр өөрийн практик болон онолын үйл ажиллагаагаар их, бага хэмжээний хувь нэмэр оруулдаг хамт олны бүтээлч ажиллагааны үйл явцын үр дүн байдаг онцлогтой.

Судалгааны бүтээлүүдэд арга зүйн мөн чанарын талаар янз бүрийн томъёолол, санал бодол байдаг боловч шинжлэх ухааны ерөнхий арга зүй бол философи гэдгийг бүх судлаач нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг. Философи арга зүй болохын хувьд судлаачийг байгаль, нийгэм, сэтгэхүйн ерөнхий хуулиуд, зүй тогтлуудын талаарх мэдлэгээр хангаж, судалж буй асуудлын харилцаа холбоог нэгдмэл ертөнцийн хүрээнд таньж мэдэх боломж олгодог.

Аливаа нийгмийн шинжлэх ухаан, түүний дотор сэтгүүл зүй шинжлэх ухааны ерөнхий арга зүйг удирдлага болгохын зэрэгцээ өөрийн гэсэн арга зүйн асуудлуудтай, мөн арга зүйн асуудлуудыг боловсруулах өвөрмөц онцлог шинжтэй байдаг. Шинжлэх ухаанд "тийм тусгай арга зүй", "тодорхой арга зүй" оршиж буйг шинжлэх ухаан судлаачид бодит байдлын тодорхой нэг хязгаарлагдмал хэсгийн зүй тогтол, харилцаа холбоогоор,

түүний хөдөлгөөний хэлбэрээр тодорхойлогддог гэж үздэг байна¹².

Аливаа шинжлэх ухааны арга зүй нь тухайн шинжлэх ухааны агуулга, нийтлэг арга болон онолын нэгдлийг илэрхийлдэг бөгөөд мэдлэгийн энэ салбарын хувьд зарчмын чухал ач холбогдолтой томоохон судалгааны асуудлын арга зүйг өөрийнхөө бүрэлдэхүүн хэсэг болгон авдаг онцлогтой.

Арга зүйн бүтэц ба судлагдахуун. Аргын тухай сургаал болох арга зүйн бүтэц ба судлагдахууны тухай асуудал бол ихээхэн маргаантай асуудлын нэг юм. Гэхдээ аргын үндэс нь онол ч биш, арга ч биш юм. Арга зүйн судлагдахуун нь мэдлэгийн систем (онол) ба үйл ажиллагааны системийн харилцан нөлөөлөл байдаг. Өөрөөр хэлбэл, арга зүйн судлагдахуун нь онолыг (объектив зүй тогтлыг) судлаачийн үйл ажиллагааны журам (арга) болгон хувиргах механизм юм. Гэхдээ зарим судлаач арга зүйг судалгааны практикаас салгахаас болгоомжилж, түүний бүтцэд танин мэдэхүйн онолын хамт судалгааны аргууд ба зарчмуудын нийлбэрийг багтаадаг байна. Судлаач А.И. Станькогийн үзсэнээр "арга зүй бол шинжлэх ухааны дүн шинжилгээ хийх ерөнхий ба тусгай аргуудын систем мөн"¹³. Энэ бүхэн нь арга зүйн бүтцийн онолын арга зүй (судлагдахуун, бүтэц, зарчим ба аргуудын мөн чанар г.м.) ба практик арга зүй (судалгаа хийх явцад

зарчим болон аргуудыг практикийн үүднээс хэрэглэх) гэсэн хоёр хэсэгт хуваах үндэслэл болдог.

Өөр нэг үндэслэл бол арга зүйн ойлголтын бүтцэд арга зүйн зарчмууд, судалгааны аргууд, арга зүйн хандлагууд гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаах боломж олгодог.

Арга зүйн зарчмууд. Шинжлэх ухааны үнэн бодитой үр дүнд хүрэхэд судалгааны зарчмуудын үүрэг, ач холбогдол үнэлж баршгүй гэдгийг шинжлэх ухааны аль ч салбарын төлөөлөгчид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг. А.Эйнштейн: "Онолч өөрийнхөө аргыг үндэс болгон хэрэглэхэд зарчим гэж нэрлэгддэг зарим нэг ерөнхий төсөөлөл зайлшгүй шаардлагатай болдог бөгөөд зөвхөн түүний тусламжтайгаар үр дагаврыг гарган авч чаддаг"¹⁴ гэж тэмдэглэсэн байдаг. Зарчим бол арга зүйн ертөнцийг үзэх үзлийн талыг илэрхийлэх онцлогтой.

Судалгааны ерөнхий зарчмуудын тоо болон тэдний хоорондох харилцаа холбооны талаар шинжлэх ухаан судлалын бүтээлүүдэд өнөөдөр хүртэл нэг мөр болсон шийдэл алга байна. Зарим судлаач судалгааны хамгийн гол зарчим болгон түүхчлэн судлах зарчим, судалгааны үнэн бодитой байх, бүх талыг хамрах зарчмыг авч үздэг. Хоёр дахь хэсэг нь бүх талыг хамрах явдал бол судалгааны ажилд тавигдах шаардлагуудын нэг бөгөөд түүний тусламжтай-

гаар түүхчлэн үзэх зарчмыг хэрэгжүүлдэг гэж үздэг байна. Ер нь арга зүйн зарчмуудын тухай маргаан бол ач холбогдолтой зүйл биш. Асуудлын гол нь зарчмуудын тоонд бус, харин тэдний нийлбэр нь танин мэдэх үйл явцад тавигдах үндсэн шаардлагуудыг илэрхийлж чадахуйц хэмжээнд маш оновчтой томъёологдсон, агуулга, мөн чанарыг нээж өгсөн байх нь чухал юм.

Гэхдээ арга зүйн үндсэн ойлголтуудын дотор "тал бүрийн ач холбогдол бүхий логикийн нийтлэг зарчим"¹⁵ болох түүхчлэн үзэх зарчим онцгой байр эзэлдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Түүхчлэн үзэх зарчим. Энэ зарчмын мөн чанар нь судалгдахууныг (үзэгдлийг) түүний өөрчлөлт, хувьсгал хөгжил, хөдөлгөөнд нь авч үзэхэд оршино. Түүхчлэн үзэх зарчим бол логикийн нийтлэг зарчим бөгөөд шинжлэх ухааны танин мэдэхүүд тавигдах арга зүйн тодорхой шаардлагуудын хэлбэрээр хэрэгждэг. Түүхчлэн үзэх гэдэг нь юуны өмнө судалж буй объектыг үнэн бодитой, тал бүрээс нь авч үзэх, түүний мөн чанарыг, ерөнхий ба тусгай зүй тогтлуудыг таньж мэдэх, түүний гадаад, дотоод бүхий л харилцаа холбоог судлах явдал мөн.

Судалж буй үзэгдэлд бодитой хандах боломжийг бүрдүүлдэг тал бүрээс нь авч үзэх явдал бол гадаад болон дотоод онцлог шинжүүдтэй юм. Дотоод талын онцлог нь судалж буй аливаа үзэгдэл, объектыг түүний тусгай шинж,

онцлогийг үндэслэж судалах боломжгүй гэдэгт оршино. Үүнийг онцлон тэмдэглэхийн учир нь гэвэл хэвлэлийн түүхийг судлах явцад ерөнхий зүйлийн тодорхой хэсгүүд, нэгжүүдийг судалгааны объект болгон авах үед үйл явц улам эрчимтэй явагдах бөгөөд алхам тутамдаа үнэлэлт дүгнэлт өгөх орон зай, хамрах хүрээний асуудал зөв эсэх нь эргэлзээ төрүүлдэг. Ерөнхий зүйл хэсэг, нэгжүүдийн хөгжилд шийдвэрлэх

үүрэг гүйцэтгэдэг нь тодорхой. Гэхдээ нэгж элементүүдээр дамжуулж аливаа судлагдахууны ямар нэгэн шинж чанар, өвөрмөц онцлогийн талаар төсөөлөл авч болдог боловч энэ нь хэсэг, нэгжүүд ерөнхий зүйлийн зөвхөн тодорхой нэг үүргийг гүйцэтгэж, төсөөлөл төдий, өнгөцхөн мэдээлэл өгдөг учраас шийдвэрлэх ач холбогдолтой болж чадахгүй¹⁶. Тиймээс хэвлэлийн тодорхой нэг хэв маягийг судлах замаар хэвлэл мэдээллийн хөгжлийн ерөнхий үйл явц, чиг хандлагын тухай, эсвэл нэг сонины (хамгийн гол сонин байсан ч) хувьсал хөгжлийг судлах замаар бүхэл бүтэн ард түмний хэвлэл мэдээллийн төлөвшлийн тухай ярих нь утгагүй юм.

Судалгааны өргөн хүрээг хамарсан янз бүрийн материалуудыг авч үзэхдээ

зөвхөн нийтлэлийн агуулгын чиг хандлагаас гадна хэвлэлийн түүхийн салшгүй хэсэг болох мэргэжлийн уран бүтээлийн хувьсал хөгжлийг судлах нь сэтгүүл зүйн түүхийг бүрэн гүйцэд судлах боломж олгодог онцлогтой. Зарим судалгааны бүтээлд материалын агуулгад гол анхаарлаа төвлөрүүлж, түүний хэлбэр, ур чадварт хэт өнгөцхөн ханддагаас сонин хэвлэлийг

зөвхөн агуулга, сэдвийн хүрээнд тоймлон судлах явдал түгээмэл ажиглагддаг. Өөрөөр хэлбэл, судалгааны объектэд олон талаас нь иж бүрэн хандах аргын талаар ихээхэн учир дутагдалтай гэж хэлж болно. Түү-

«
Энэ зарчмын мөн чанар нь судалгдахууныг (үзэгдлийг) түүний өөрчлөлт, хувьсал хөгжил, хөдөлгөөнд нь авч үзэхэд оршино. Түүхчлэн үзэх зарчим бол логикийн нийтлэг зарчим бөгөөд шинжлэх ухааны танин мэдэхүйд тавигдах арга зүйн тодорхой шаардлагуудын хэлбэрээр хэрэгждэг.

»

хийн шинжлэх ухаан нийтлэлийн агуулгад анхаарлаа төвлөрүүлэх замаар судлагдахууныг олон талаас нь таньж мэдэх зорилгоор хэвлэл мэдээллийн мэргэжлийн, уран бүтээлийн, хэл найруулгын асуудалд илүү их анхаарлаа хандуулах ёстой.

Судалгааны үр дүн, судлаачдын туршлагаас үзэхэд аливаа сонин хэвлэлийн шинжлэх ухааны томъёолол нь наад зах нь түүний үүсэл хөгжил, зохион байгуулалтын түүх, агуулга ба сэдвийн судалгаа, уран бүтээлийн дүр төрх гэсэн гурван бүрэлдэхүүн хэсгээс

тогтдог байна. Иж бүрэн хандах шаард- лагуудыг, тодруулж хэлбэл түүхчлэн судлах зарчмыг ойлгох нь тухайн суд- лагдахууны урьдач нөхцлийг тогтоох, түүний өмнөх үеийн түүхийг таньж мэдэх явдалтай салшгүй холбоотой юм.

Аливаа шинэ үзэгдэл хэзээ ч, хаана ч хоосон газар, хоосон зүйлээс үүсэж бий болдоггүй. Өмнөх үеийн хөгжлээр бий болсон тодорхой урьдач нөхцөлийн үндсэн дээр үүсэж хөгждөг. Дэвшүүлэн тавьж буй үзэл санааг үнэн бодитой, үндэслэлтэй болгохын тулд тухайн үеийн судлагдахууны түүх болон өмнөх үеийн урьдач нөхцлийн хоорондох, одоогийн байдал болон өмнөх үеийн байдлын хоорондох харилцаа холбоог нарийн тогтоосон байх шаардлагатай. Учир нь үүсэл хөгжлийн харилцаа холбоо, залгамж чанар тасарсан нөх- цөлд танин мэдэхүйн үйл явц зайлшгүй мухардалд ордог жамтай юм. Урьдач нөхцөл бол нэгж үзэгдэл, үйл явц буюу судлаачийн хэлсэнчлэн “өөрийгөө хэрэглэхийг шаардаж, бас хүлээж буй тархай бутархай материал”¹⁷ гэж ойл- гож болно. Тиймээс энэ материалуу- даас тухайн судалгааны судлагдахуун урган гардаг онцлогтой юм. Сэтгүүл зүйн түүхийг судлаачид сэтгүүл зүйн салбарын аливаа асуудал, үзэгдлийг судлах явцад тухайн судлагдахуунд илүү их анхаарал хандуулддагаас түүний урьдач нөхцөлийн тухай

асуулыг харьцангуй ховор хөнддөг нь ажиглагддаг.

Түүхчлэн судлах зарчмыг тухайн судлагдахууны үүсэж бий болсон урь- дач нөхцөл, одоогийн байдлын хоорон- дох зааг ялгааг нарийн тодорхойлж чадаагүй тохиолдолд амжилттай хэрэг- жүүлэх боломжгүй юм. Үүний учир шалтгаан нь тухайн үзэгдлийн урьдач нөхцөл нь тэр үзэгдэл бий болоогүй байхад түүнээс үл хамааран оршиж байсан бөгөөд үзэгдлийн дотоод мөн чанараас урган гараагүй байдагтай холбоотой. Өөрөөр хэлбэл, түүнээс өмнөх үзэгдлүүдийн нөлөөгөөр бий болсон, тухайн судлагдахууны жинхэнэ хөгжил, одоогийн түүх нь эхэлсэн тэр цэгийн гадна оршиж байсан гэсэн үг.

Түүхчлэн судлах зарчим нь тухайн судлагдахууныг өмнөх үеийн үзэгдлүү- дийн түүхээс ялгаж болох тэр эхлэлийг тогтоож, дараа нь бүх анхаарлаа зөвхөн түүний түүхийг судлахад хан- дуулж, өөрийн гэсэн түүхэн нөхцөл байдал, өвөрмөц зүй тогтол, шинж чанар бүхий хөгжлийн үндсэн үе шатыг тогтоохыг шаарддаг онцлогтой. Үүнээс үзэхэд шинжлэх ухааны үүднээс үечлэх гэдэг нь түүхчлэн судлах зарчмаас урган гарсан хамгийн гол шаардлуудын нэг мөн.

Хөгжлийн тасралтгүй байх чанарын тухай үзэл санаа бол түүхийг урсгал шинжтэй, тасралтгүй үргэлжлэх үйл явц гэж үзэх явдал биш юм. Аливаа зүйлийн, эсвэл үзэгдлийн хувьсал

хөгжлийг түүний хөгжлийн чанарын хувьд өөр өөр үе шатуудын нэг нь нөгөөгөөр ээлжлэн солигдох үйл явц (эгнээ) гэж ойлгож болно. Гэхдээ тэдний хоорондох зааг ялгааг хүчээр, санааны зоргоор тогтоож болохгүй бөгөөд гол үе шатуудын хооронд залгамж холбоо зайлшгүй оршиж байдаг онцлогтой. Энэхүү залгамж холбоо нь янз бүрийн үе шатуудын зүй тогтлуудыг адилтган үзэх үндэслэл болохгүй. Танин мэдэхүйн зорилго нь тухайн судлагдахууны хөгжлийн үечлэлийг нарийн тогтоох, түүхэн хөгжлийн тодорхой үе шат бүрийг түүний бодит нөхцөл байдал, жам ёсны хөгжил, объектив мөн чанарын үндсэн дээр тодорхойлохыг шаарддаг.

Судалгааны аргууд. Арга зүйн суурь ойлголтуудын нэг болох судалгааны аргын зарчмаас ялгагдах гол онцлог нь судлаачид тодорхой зорилтуудыг шийдвэрлэхийн тулд хэрэглэж буй тусгай үйлдэл, эсвэл хоорондоо нягт холбоотой, цэгцлэгдсэн үйлдлүүдийн нийлбэр байх явдал юм. Өөрөөр хэлбэл, танин мэдэх үйл ажиллагааны идэвхтэй хэлбэр гэж ойлгож болно. Арга зүй судалгааны дэг журам, аргууд болон үйл явцын дарааллыг зохицуулдаг дүрэм журмын системийг боловсруулдаг онцлогтой.

Шинжлэх ухаан судлаачид судалгааны аргын бүтэц, агуулга, учир шалтгааныг тайлбарлах оролдлогыг байнга хийдэг боловч одоо хүртэл нэг

мер болсон ойлголтонд хараахан хүрч чадаагүй бөгөөд тэдний тайлбар хоорондоо ихээхэн зөрчилтэй байгаа нь ажиглагддаг. Тухайлбал, сэтгүүл зүй судлаачид түүхчлэн судлах, социологийн, хэл шинжлэлийн, сэтгэл зүйн, харьцуулан судлах, статистикийн, бичлэгийн төрөл зүйлийн, агуулгын, намтарчилсан, логикийн зэрэг аргуудыг янз бүрийн төвшинд, янз бүрийн дараалалд авч үздэг байна.

Сэтгүүл зүйн судалгааны хувьд хэд хэдэн бүлэг аргуудыг ашиглах талаар ярьж болно. Энэ бол нэгдүгээрт, шинжлэх ухааны ерөнхий аргууд болон хийсвэр логикийн (ажиглалт, туршилт, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, индукци, дедукци г.м.) аргууд юм. Хоёрдугаарт, сэтгүүл зүйн өвөрмөц онцлогт тохируулан хэрэглэх боломжтой нийгмийн шинжлэх ухааны нийтлэг аргууд, гуравдугаарт, түүх хэл шинжлэл талаас нь таньж мэдэхэд чиглэгдсэн өвөрмөц аргууд (түүхэн харьцуулан судлах, эх бичгийн судалгаа, бичлэгийн төрөл зүйл-хэл найруулгын судалгаа г.м.) болно.

Судалгааны арга зүйн асуудлыг боловсруулах явцад зарим судлаач сэтгүүл зүйн судлалын өөрийн гэсэн өвөрмөц аргыг олохыг хичээж, “сэтгүүл зүй өргөн хэрэглэж буй аргуудын алинд ч өөрийн нэрийг өгч чадаагүй”¹⁸ талаар сэтгэл дундуур байгаагаа нэг бус удаа илэрхийлж байв. Гэхдээ асуудалд тэгж

хандах нь үндэслэл муутай гэдгийг цаг хугацаа харуулсан бөгөөд өөрийн гэсэн өвөрмөц судлагдахуунтай нийгмийн олон шинжлэх ухаан "өөрийн" аргыг бий болгож чадаагүй юм. Тэгсэн мөртлөө маш эрчимтэй хөгжиж байна. Зарим судлаачийн бодлоор орчин үед шинжлэх ухааны нийтлэг аргууд сэтгүүл зүйн судалгааны арга болон хувирч, өөрийн гэсэн өвөрмөц шинжтэй болж байгаа нь улам тод мэдрэгдэж байна. Нэг тогтмол хэвлэлийг, эсвэл хэд хэдэн хэвлэлийг судлах явдал бол тайлбарлах, тоймлох, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, ангилах аргын аль алиныг тодорхой төвшинд хэрэглэх замаар үр дүнд хүрдэг нь ойлгомжтой. Гэхдээ энэ нь биологи, хэл шинжлэл, газар зүйд хэрэглэх дээрх аргуудаас арай өөр, тухайн шинжлэх ухааны өвөрмөц онцлогийг илэрхийлсэн байдаг онцлогтой юм.

Мөн сүүлийн үед сэтгүүл зүйн судалгаанд байгалийн болон холимог шинжлэх ухааны, шинжлэх ухааны олон салбарыг хамарсан нийтлэг аргуудыг түгээмэл ашигладаг болсон нь сэтгүүл зүй судлал дахь шинэлэг хандлага, идэвхтэй эрэл хайгуулын үр дүн гэж хэлж болно. Тухайлбал, байгалийн болон нийгмийн шинжлэх ухаанд өргөн хэрэглэдэг, шинжлэх ухааны нийтлэг аргуудын нэг болох хэв маягийг тогтоох аргыг сэтгүүл зүйн судалгаанд түгээмэл хэрэглэдэг болсон бөгөөд зарим

судлаач сэтгүүл зүйн судлалын арга болон хувирсан гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Баруун Европын шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэдэг социологийн болон тоон үзүүлэлтийн аргыг сэтгүүл зүйн түүхийн судалгаанд нэвтрүүлэх нь цаг үеийн чухал шаардлагын нэг болж байна. Түүхийн судалгааны энэ аргуудыг ямар ч тохиолдолд бус, зөвхөн хэрэглэх боломжтой, хангалттай баримт мэдээлэл байгаа тохиолдолд л хэрэглэх шаардлагатай гэдгийг эрдэмтэд хүлээн зөвшөөрдөг. Судлаач Э. Клиффегийн бодлоор түүхийн судалгааны хувьд тоон үзүүлтийн арга бол хамгийн гол арга бус бөгөөд уламжлалт баримтын судалгаанд нэмэлт мэдээлэл өгөх, итгүүлэн үнэмшүүлэх чадварыг дээшлүүлэх, улам тодорхой болгоход нөлөөлдөг байна¹⁹. Тоон үзүүлэлтийн дүн шинжилгээ нь судлаачид тоо баримтын тусламжтайгаар зөвхөн логик бодол санааг баталгаажуулах төдийгүй, нэгжээс ерөнхий рүү шилжих явцад түүхийн шинжлэх ухаанд харьцангуй ховор тааралддаг дүгнэлтийх боломж олгодог онцлогтой. Сэтгүүл зүйн түүхэнд тоон үзүүлэлтийн аргад болгоомжтой ханддаг нь янз бүрийн хардалттай холбоотойгоос гадна тоон үзүүлтүүдийг нэгтгэх явцад судлаачдын хувийн үзэл бодол, нийгмийн захиалга, таамаглалаас шалтгаалан бодит байдлыг гуйвуулах, алдаа гаргах, буруу зөрүү мэдээлэл өгөх

магадлал өндөр гэдгийг ойлгосонтой холбоотой юм.

Шинжлэх ухаан судлалын бүтээлүүдэд "судалгааны арга"-ын хамт "арга зүйн хандлага" хэмээх ойлголт түгээмэл тааралддаг. Хэдийгээр энэ нэр томъёоны талаарх судлаачдын үзэл бодол ихээхэн зөрчилтэй боловч судалгаанд, түүний дотор сэтгүүл зүйн судлалд идэвхтэй хэрэглэж эхэлсэн нь ажиглагддаг.

Арга зүйн хандлага гэдгийг янз бүрийн арга, шинжилгээний дэг журмыг танин мэдэхүйн болон логикийн тодорхой нэгдэлд ашигласан судалгааны иж бүрэн арга зам гэж ойлговол зохино. Танин мэдэхүйн онолын үндсийг хүрээлэн буй ертөнцийг судлах түүхчлэн судлах (судлагдахууны өөрчлөлтийг түүхийн үүднээс тусгах), логикийн (судлагдахууны өөрчлөлтийг онолын үүднээс тусгах) зэрэг хоёр чухал арга бүрдүүлдэг. Энэ хоёр аргыг түүхчлэн үзэх аргад үндэслэгдсэн, мөн чанарын хувьд анхдагч, хамгийн амьдрах чадвар сайтай учраас бодит байдлыг таньж мэдэх арга зүйн хандлага гэж үздэг байна. Дээрх аргуудын ялгаа нь түүхчлэн судлах арга судлагдахууны үүсэл, хөгжлийн үйл явцыг илэрхийлдэг бол логикийн арга түүхчлэн үзэхийн нэгэн адил боловч тохиолдлын шинжтэй, санамсаргүй зүйл, янз бүрийн гажилтаас ангид байдагт оршино. Хэрэв түүхчлэн үзэх хандлага судлагдахууны түүхийг илэр-

хийлж, түүний онолын түлхүүр болдог бол логикийн арга тэр онолыг бий болгодог.

Судалгаанд түүхчлэн үзэх болон логикийн аргыг ашиглах нь судалж буй объектын түүхэн хөгжлийн үе шат бүрдэх онцлог шинж, мөн чанар, нөхцөл байдал, түүний хувьсал хөгжлийн зүй тогтол, чиг хандлагын талаар тодорхой мэдлэг олж авахад нөлөөлдөг.

Арга зүйн хандлага болох танин мэдэхүйн түүхчлэн үзэх, логикийн аргууд бол сэтгүүл зүйн судлалд өөрийн уламжлалтай, дэг жагятай, янз бүрийн хувилбартай байдаг. Харин ямар арга, хандлагыг ямар төвшинд сонгож авах нь судалгааны зорилго, шинж чанараас шалтгаалдаг онцлогтой.

Түүхчлэн үзэх хандлагыг сэтгүүл зүйн судалгаанд синхрон ба диахроны задлан шинжилгээ гэсэн үндсэн хоёр чиглэлээр хэрэглэдэг уламжлалтай. Сэтгүүл зүйн хөгжлийг синхроны аргаар судлана гэдэг бол сэтгүүл зүйн баримтуудыг нийгэм-улс төрийн үйл явц, нөхцөл байдалд тохирч буй эсэхийг харгалзан авч үзэх, дүн шинжилгээ хийж, харьцуулан судлах үйл явц бол диахроны арга нь сэтгүүл зүйн баримтуудыг түүний дотоод хөгжил, мөн чанар, залгамж холбоо, зүй тогтлын үүднээс судлахыг зорилго болгодог ажээ.

Түүхчлэн үзэх хандлагын ийм хоёр төрөл зэрэгцэн орших нь гүн гүнзгий

үндэслэлтэй, жам ёсны үйл явц мөн. Нэг дэх нь аливаа нийгэм, түүхийн судалгаанд голлон баримталдаг хандлага бөгөөд сэтгүүл зүйн улс төрийн мөн чанарыг, хоёр дахь нь уран бүтээлийн талыг судалж, ихэнх тохиолдолд хэл бичгийн судалгаагаар хязгаарлагддаг. Өөрөөр хэлбэл, өргөн утгаар нь нэг дэх нь гадаад хүчин зүйлийн нөлөөг, хоёр дахь дотоод хүчин зүйлийн нөлөөг голлон судалж, үнэлэлт дүгнэлт өгдөг арга гэж ойлгож болно.

Судалгааны практикт аль аль нь өөрийн гэсэн бэрхшээлтэй, шийдвэрлэх асуудалтай байнга тулгардаг. Тухайлбал, сэтгүүл зүйг синхроны аргаар авч үзэх гол нөхцөл, үндэслэл нь нийгмийн хөгжлийн үйл явц, үе шатыг бүхэлд нь тусгасан иргэний түүхийн суурь судалгаа зайлшгүй байх явдал юм. Тэгвэл диахроны аргаар судлахын гол бэрхшээл нь сэтгүүл зүйн уран бүтээл, мэргэжлийн тал нь утга зохиолын үйл ажиллагааны нэгэн адил бүх зүйлийг нэг төвшинд адилтган үзэх, механикаар өнгөцхөн хандах, цөөхөн хэдэн баримтын хүрээнд үнэлэт өгөх боломжгүй байдагтай холбоотой юм.

Сүүлийн үед сэтгүүл зүйг синхрон ба диахроны аргаар судлах явдал системийн дүн шинжилгээ хийх үндсэн дээр нэлээд идэвхтэй хэрэгжиж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, системийн дүн шинжилгээний хүрээнд сэтгүүл зүйг

ерөнхий системийн хэсэг болгон авч үзэхээс гадна түүний дотоод системийг бүрдүүлдэг хэвлэл мэдээллийн төрөл хэлбэр, хэв маягууд, онолын үндсэн ойлголтууд, тулгамдсан асуудлуудад ихээхэн анхаарал хандуулдаг болсон юм.

Сэтгүүл зүйн судалгааны зарим бүтээлд түүхчлэн үзэх, логикийн аргыг хослон хэрэглэж онол-түүхийн иж бүрэн хандлагыг түлхүү барих оролдлого ажиглагдах болсон нь сэтгүүл зүйн судлал дахь шинэ үзэгдэл юм. Судлаачдын үзсэнээр онол-түүхийн иж бүрэн хандлага асар их ирээдүйтэй бөгөөд зөвхөн ийм бүтээлүүд л "судлаач бүх материалуудыг цогц байдлаар нь авч үзэж, түүнийг өнгөцхөн тайлбарлахгүйгээр зөвхөн өмнөх тайлбаруудад үндэслэн шинжлэх ухааны хувьд ач холбогдолтой, үндэслэлтэй, чухал дүгнэлтүүдийг хийх боломж олж авдаг..."²⁰ байна.

Онол-түүхийн хандлага. Сэтгүүл зүйг судлах онол-түүхийн хандлага бол зөвхөн түүхчлэн үзэх, эсвэл логикийн хандлагатай харьцуулахад уламжлал багатай, олон асуудал нь тодорхой бус байгаагийн зэрэгцээ судалгааны бүтээлүүдэд энэ хандлагын талаарх ойлголт хараахан нэг мөр болоогүй юм. Судлаачдын нэг хэсэг нь "онолын түүх", нөгөө хэсэг нь "онолжсон түүх", гурав дахь хэсэг нь түүхэн материалуудаас урган гарсан зүй тогтол ба чиг хандлага гэж ойлгодог. Энд нэр

томъёог янз бүрээр тодорхойлох нь чухал биш, харин нэг бүтээлд нэг зорилгыг шийдвэрлэхийн тулд онолын ба түүхийн хандлагыг хослон хэрэглэх замаар тодорхой үр дүнд хүрэх нь чухал юм.

Сэтгүүл зүйг судлахад онол-түүхийн хандлагыг хэрэглэх зайлшгүй шаардлага шинжлэх ухааны мэдлэгийн хөгжлийн хэрээр тоймлон тайлбарлах, баримт цуглуулж дүн шинжилгээ хийх, янз бүрийн туршилт хийх замаар судалгаа хийх нь ихээхэн хязгаарлагдмал байгаагаас урган гарч байна. Мэдээллийн хэрэгслүүдийн нийтлэл, нэвтрүүлгийн талаар баримт мэдээлэл цуглуулж, судалгааны эргэлтэнд оруулах, асуудлын бүх талыг хамрах, баримтыг тодорхой дэс дарааллын дагуу тайлбарлах зэрэг нь шинжлэх ухаанд зайлшгүй шаардлагатай, жам ёсны үе шат мөн. Орчин үед гол гол мэдээллийн хэрэгслүүдийн талаар ямар нэг төвшинд судалгаа хийгдэж, сонирхолтой мэдээлэл баримтын сантай болсон ч тэр баримтуудын цаана оршиж буй зүй тогтлуудыг, мэдээллийн хэрэгслүүдийн хэв маягуудын нийтлэг шинж, өвөрмөц онцлогийг олж харсан, орчин үеийн сэтгүүл зүйн практикт үнэхээр чухал, цаг үеэ олсон, ач холбогдол сайтай дүгнэлт хийж, зөвлөмж боловсруулсан судалгааны бүтээл өдрийн од шиг ховор байна. Орчин үед сэтгүүл зүйн судалгааны хэрэгцээ шаардлага, онцлог шинж нь баримт

мэдээллийг цуглуулах, тайлбарлан бичихийн зэрэгцээ ОНМХ-үүдийн хэв маяг, бичлэгийн төрөл зүйл, сэтгүүлчийн ур чадвар, бүтээлч үйл ажиллагааны хэлбэр төрлүүдийн хөгжлийн ерөнхий зүй тогтлуудыг тогтоох, сэтгүүл зүйн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрж хайх, өргөн хүрээг хамарсан даацтай дүгнэлт хийх хандлагаар тодорхойлогдох ёстой.

Сэтгүүл зүйг судлахад онол-түүхийн хандлагыг ашиглах нь онолын асуудлыг боловсруулах (онолын мэдлэгийг бий болгох), об'ектив зүй тогтлуудыг илрүүлэх замаар онол, түүхийн хоорондох харилцаа холбоог бэхжүүлэх арга зүйн гүүр болох үүргийг гүйцэтгэдэг. Энэ хандлагын арга зүйн ач холбогдол нь боловсруулсан онолын үндэслэл нь шинжлэх ухааны мэдлэгийн хөгжлийн явцад танин мэдэхүйн үйл ажиллагааны удирдамж болж, арга зүйн үүргийг гүйцэтгэхэд оршино. Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүйн онолын үндэслэл, дүгнэлт зэрэг нь танин мэдэхүйн болон зохицуулах зарчим болон хувирч байна. Ийм зарчмуудын тусламжтайгаар онолын ба арга зүйн мэдлэгийн, онол ба арга зүйн хоорондох харилцаа холбоог, түүний учир шалтгааныг илрүүлэх, тайлбарлах боломжтой юм.

Түүхчлэн үзэх ба логикийн аргын нэгдэлд үндэслэгдсэн онол-түүхийн хандлага сэтгүүл зүйн шинжлэх ухааны

хамгийн чухал зорилтуудын нэг болох үндсэн категориудын системийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болно. Судалж буй объектын зөвхөн түүхийг судлахаас гадна энэ талаарх мэдлэгийн үүсч боловсорсон үйл явц, тэр түүхийг тусгаж буй үндсэн ойлголт, категориудын түүхийг давхар авч үзэх шаардлагатай. Сэтгүүл зүйн шинжлэх ухаанд үндсэн ойлголтуудыг тодорхойлох оролдлого, янз бүрийн маргаан мэтгэлцээн тодорхой хэмжээнд өрнөж байсан ч өнөөдөр хүртэл үндсэн категориудын хүлээн зөвшөөрөгдсөн систем алга, хамгийн гол гол ойлголтуудыг бүрэн төгс тодорхойлж чадаагүй байна. Хэрэв судлагдахууны гол зөрчлийг илэрхийлж чадахуйц үндсэн ойлголт, нэр томъёоны зүй тогтлыг (хууль) боловсруулж чадсан тохиолдолд тухайн шинжлэх ухаан өөрийн зорилгод хүрдэг гэсэн үзэл баримтлалыг иш үндэс болговол сэтгүүл зүй энэ зорилго руу дөнгөж эхний алхам хийж байна гэж хэлэх үндэстэй. Үүний гол шалтгаан нь онол-түүхийн иж бүрэн хандлагыг ашиглаж ирсэн уламжлал байгаагүй, үүнийг судалгаанд хэт орой хэрэглэж эхэлсэнтэй холбоотой юм.

Сэтгүүл зүйн хөгжлийн өнөөгийн төвшин энэ чиглэлийн аливаа судалгааны арга зүйн үндсийг чиглэсэн зорилготой, маш нямбай боловсруулахыг шаардах болсон. Судалж буй асуудлыг арга зүйн үүднээс сайн

эзэмших нь судлагдахууныг болон судалгааны зорилго, зорилтуудыг үнэн зөв, оновчтой тодорхойлох, эрдэм шинжилгээний эрэл хайгуулын үр ашгийг дээшлүүлэх, практикийн өндөр ач холбогдолтой, цаг үеэ олсон, үндэслэл сайтай дүгнэлт хийх боломж олгодог.

Сэтгүүл зүйг шинжлэх ухааны үүднээс таньж мэдэх үйл явц нэлээд эрчимжиж, хөгжлийн шинэ шатанд гарсан нь судалгааны арга зүйг шинжлэх ухааны мэдлэгийн тусгай салбар гэж үзэх дүгнэлтэнд хүргэсэн.

Нийгмийн шинжлэх ухааны уламжлалт салбаруудад энэ асуудлыг аль хэдийд хүлээн зөвшөөрч, нэгдсэн дүгнэлтэнд хүрснийг тэмдэглэж хэлэх хэрэгтэй. Тухайлбал, өнгөрсөн зууны эхэнд түүхийн шинжлэх ухааны судлагдахуун нь түүхийн үйл явц биш, "энэ үйл явцыг таньж мэдэх арга болон тэр танин мэдэхүйн бидний ухамсраас хараат бус орших байдал"²¹-ыг өөрийн судлагдахуун болгосон түүхийн шинжлэх ухааны шинэ чиглэл бий болсон юм.

Сэтгүүл зүйн судалгааны арга зүйг бие даасан салбар ухааны төвшинд авч үзэхийг аливаа салбар шинжлэх ухааныг бий болгох үндэс суурь нь түүний судлагдахуун ба зорилгын бүх нийтээрээ хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байдаг гэсэн үндэслэлээр эсэргүүцэж, маргаж болох талтай. Гэхдээ тийм тодорхойлолт өөрөө маргаантай асуудал хэвээр байна.

Харин шинжлэх ухааныг өөрсдийн судалгааны үйлдлүүдийг тунгаан бодоход чиглэгдсэн эрдэмтдийн үйл ажиллагааны хэлбэрийг илэрхийлдэг онцгой төрлийн систем гэдгийг хүн бүхэн хүлээн зөвшөөрсөн байдаг.

Цаашид танин мэдэхүйн үйл ажиллагааг судалдаг чиглэлийн хувьд сэтгүүл зүйн судалгааны арга зүйг бие даасан салбар ухаан болгохын тулд нэлээд боловсронгуй болгох шаардлага тулгарч байна. Ийм салбар ухаан төлөвшиж эхэлснийг судалгааны зорилго, судлагдахуун нь тусгаарлагдсан буюу сэтгүүл зүйн онол, практик, түүхийг таньж мэдэх тулгамдсан асуудлуудыг цогц байдлаар судлах болсон, мөн арга зүйн асуудлаар харьцангуй бие даасан шинжтэй бүтээлүүд гарч эхэлсэн, судалгааны янз бүрийн төвүүдэд олон нийтийн мэдээллийн харилцааг судлах шинжлэх ухааны аргын хувьд төрөлжсөн чиглэлүүд бий болсон зэрэг баримтууд харуулж байна.

Ишлэл

¹ Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.

² Дэлэг Г. 1971. 1972. Монголын хэвлэл. I, II боть. УБ.

³ Норовсүрэн Л. 2000, 2001, 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. I, II, III боть. УБ.

⁴ Норовсүрэн Л. 2004, 2005, 2007. Монголын нийтлэл. I, II, III боть. УБ.

⁵ Дэлэг Г., Үржинбадам Д. 1984. Хэвлэлийн онол, дадлага. УБ.

⁶ Нямсүрэн Д. 1985. Сэтгүүлчийн ур чадвар. УБ.

⁷ Баасансүрэн Т. 1984. Тэргүүн туршлагыг хэвлэлээр сурталчлах асуудалд. УБ.

⁸ Галдан Т. 1977. Телевидение МНР: проблемы его становления и основные тенденции развития. Канд. дисс. М.; Эрдэнэтуяа Ю. 1984. Пропаганда коммунистического идеала как средство нравственного воспитания молодежи. Канд. дисс. М.; Пунсаа Ц. 1988. Воздействие ТВ на повышение трудовой активности масс. Канд. дисс. М.

⁹ Зулькафил М. 1997. Орчин үеийн монголын сэтгүүл зүй. УБ.

¹⁰ 2003. Чөлөөт хэвлэлийн төлөвшил, олон нийтийн санал бодол (Төслийн тайлан). УБ. МУИС.

¹¹ 2000-2006. Монголын хэвлэл мэдээлэл. Мониторинг УБ. МХХ. 11 цуврал.

¹² Штофф В. А. 1975. Современные методологии научного познания. Л., с. 5.

¹³ 1979. Методы исследования журналистики. Ростов-на-Дону, с. 43.

¹⁴ Эйштейн А. 1965. Физика и реальность. М., с. 5.

¹⁵ Кухановский В. П. 1973. Историзм как принцип диалектической логики. Ростов-на-Дону, с. 2.

¹⁶ Петряев К. Д. 1971. Вопросы методологии исторической науки. Киев, с. 36.

¹⁷ Гегель. Собр. соч. Т. 6. М., с. 150.

¹⁸ Симкин Я. Р. 1974. Современные методы исследования журналистики // Методы исследования журналистики. Ростов-на-Дону. с. 4.

¹⁹ Клиффе Э. 1981. Исследовательские методы массовой коммуникации. М., с. 88.

²⁰ Есин Б. И. 1977. О методике историко-журналистских исследований // Методика изучения периодической печати. М., с. 6.

²¹ Цит по книге: 1911. Журналистика на рубеже тысячелетий. Ростов-на-Дону. с. 17.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 1984. Тэргүүн туршлагыг хэвлэлээр сурталчлах асуудалд. УБ.

2. Галдан Т. 1977. Телевидение МНР: проблемы его становления и основные тенденции развития. Канд. дисс. М.

3. Гегель. Собр. соч. Т. 6. М.

4. Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
5. Дэлэг Г. 1971, 1972. Монголын хэвлэл. I, II боть. УБ.
6. Дэлэг Г., Үржинбадам Д. 1984. Хэвлэлийн онол, дадлага. УБ.
7. Есин Б. И. 1977. О методике историко-журналистских исследований // Методика изучения периодической печати. М.
8. 1911. Журналистика на рубеже тысячелетий. Ростов-на-Дону.
9. Зулькафиль М. 1997. Орчин үеийн монголын сэтгүүл зүй. УБ.
10. Клиффе Э. 1981. Исследовательские методы массовой коммуникации. М.
11. Кохановский В. П. 1973. Историзм как принцип диалектической логики. Ростов-на-Дону.
12. 1979. Методы исследования журналистики. Ростов-на-Дону.
13. 2000-2006. Монголын хэвлэл мэдээлэл. Мониторинг. УБ. МХХ. 11 цуврал.
14. Норовсүрэн Л. 2000, 2001, 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. I, II, III боть. УБ.
15. Норовсүрэн Л. 2004, 2005, 2007. Монголын нийтлэл. I, II, III боть. УБ.
16. Нямсүрэн Д. 1985. Сэтгүүлчийн ур чадвар. УБ.
17. Петряев К. Д. 1971. Вопросы методологии исторической науки. Киев.
18. Пунсаа Ц. 1988. Воздействие ТВ на повышение трудовой активности масс. Канд. дисс. М.
19. Симкин Я. Р. 1974. Современные методы исследования журналистики // Методы исследования журналистики: Ростов-на-Дону.

20. Штофф В. А. 1975. Современные методологии научного познания. Л.

21. 2003. Чөлөөт хэвлэлийн төлөвшил, олон нийтийн санал бодол (Төслийн тайлан). УБ. МУИС.

22. Эйштейн А. 1965. Физика и реальность. М.

23. Эрдэнэтуйа Ю. 1984. Пропаганда коммунистического идеала как средство нравственного воспитания молодежи. Канд. дисс. М.

Резюме

В статье дается анализ методологии, методов и принципов исследования журналистики. Автор опираясь на опыты исследования монгольской журналистики делает вывод о том, что в структуре научного познания большую ценность приобретают не только текущие результаты исследований, но и логика, принципы, приемы и методы, с помощью которых познается предмет, описываются и объясняются происходящие процессы. Поэтому автор с этой точки зрения рассматривает вопросы методологии и методы исследования монгольской журналистики и выявляет некоторые недостатки в этом направлении, подчеркивает основные факторы, влияющие на эти недостатки. Также автор подчеркивает сущность методологии как теории познания и совокупности принципов и методов исследования, предмет и структуру методологии, соотношение методологических и теоретических проблем в науке, методологию и методику познания.